



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/170

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “г” дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.5 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 тоот тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний тодотгол”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Гранд гоби экспедишн” ХХК (РД:6416624)-д худалдаа, үйлчилгээний газрын зориулалтаар сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр “Их тойруу 9-908” тоотод байршилтай 10000 м.кв (1 га) газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Миеэсүрэн) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч “Гранд гоби экспедишн” ХХК-ийн захирал (Б.Мөрөн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ